



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/302

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 дэхь заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны А-96/71 тоот тушаалын хавсралтаар баталсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын 2019 онд байгуулсан гэрээнд тусгагдсан Ойжуулалт, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд хийгдсэн ойн зурвасын ажлын гүйцэтгэлийг шалган хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Гантулга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
Гишүүд:	П.Очирбат (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Цэрэнсугир (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)
	Ц.Галбадрах (Сум дундын ойн ангийн дарга)
	П.Уртнасан (Сум дундын ойн ангийн мэргэжилтэн)

Хоёр. Ойжуулалт, ойн зурваст тарьж ургуулсан тарьц, суулгацын амьдралтын хувь хэмжээг бодитой тогтоож, акт, танилцуулгыг 2019 оны 9 дүгээр сарын 28-ны дотор холбогдох газруудад хүргүүлэхийг ажлын хэсэг (Н.Гантулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190880